



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 445

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Ц.Шинэхүүг томилсугай.

2. Төрийн өмчийн төлөөлөгчийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Ц.Шинэхүүд даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000898

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн
445 дугаар тогтоолын хавсралт

**“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД
ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ
УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон дараах удирдамжийг баримтална:

1. Засгийн газрын 2018 оны “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 387 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Тавантолгой түлш” ХХК-ийн үйл ажиллагааны стратеги, дүрмийн төсөлд санал өгч оролцох.
2. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг төлөөлж Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Ц.Шинэхүүг сонгож, томилох, хараат бус гишүүдийг Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулахад санал өгч оролцох.
3. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд санал өгч оролцох.